

**АРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА ГАЗРЫН ХАРИЛЦАА,
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГАТАЙ
2025 ОНД БАЙГУУЛСАН ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭ**

НЭГ. ГЭРЭЭ БАЙГУУЛАГЧ ТАЛУУД

1.1.Нэг талаас Төсвийн ерөнхийлөн захирагч, аймгийн Засаг дарга **Бямбадоогийн Цэрэннадмид**, нөгөө талаас Төсвийн шууд захирагч, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга **Чойдогдэмидийн Отгонжаргал** нар Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх заалт, Засгийн газрын 2023 оны 217-р тогтоолыг тус тус үндэслэн дор дурдсан асуудлаар харилцан тохиролцож энэхүү гэрээг 2025 оны 01 дугаар сарын 24-ний өдөр байгуулав.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ АГУУЛГА, ЗОРИЛГО

2.1. “Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө” нь энэхүү гэрээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг бөгөөд гэрээнд манлайллын зорилт, мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт тэдгээрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүн)-үүд болон талуудын эрх үүргийг тусгав.

2.2. Энэхүү гэрээний зорилго нь Төрийн албаны тухай хууль, холбогдох дүрэм журам, стандарт, ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, авлига, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах, үйл ажиллагаагаа оновчтой төлөвлөж хэрэгжүүлэх, албан тушаалын шаардлагад нийцүүлэн мэдлэг чадвараа дээшлүүлэх, байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, төсвийн болон эд хөрөнгийг зохистой ашиглах, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх зэрэг манлайллын зорилтуудыг хангах талаар төсвийн шууд захирагчийн тухайн жилд гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхойлоход оршино.

ГУРАВ. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

3.1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн хүлээх үүрэг

3.1.1. Манлайллын зорилтууд, тэдгээрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, биелэлтэд хяналт тавина.

3.1.2. Тухайн төрийн байгууллага болон эрх шилжүүлсний үндсэн дээр байгууллагын хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний санхүүжилтийг хугацаанд нь хийнэ.

3.1.3. Гэрээнд тусгагдсан манлайллын зорилтоо хэрэгжүүлэхэд нь төсвийн шууд захирагчид дэмжлэг туслалцаа үзүүлж, гэрээний биелэлтийг хангах боломж, нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

3.1.4. Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэгт заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

3.2. Төсвийн шууд захирагчийн хүлээх үүрэг

3.2.1. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”, Шинэ сэргэлтийн бодлого, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөө зэрэг урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдийг хэрэгжүүлэх хүрээнд:

3.2.1.1. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан шаардлага, зарчмын дагуу өөрийн чиг үүргийн хэмжээний төлөвлөлтийг

дээрх бодлогын баримт бичгүүдтэй уялдуулах, дэвшүүлсэн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн байдлаар төлөвлөж бодлогын нэгдмэл цогц байдлыг хангаж ажиллах,

3.2.1.2. Төрийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж, хүнд суртлыг багасгах, авлига үүсэх эрсдэлийг бууруулах;

3.2.1.3. Төрийн албаны хүний нөөцийг чадавхжуулах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээг хэрэгжүүлэх, төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгох;

3.2.1.4. Засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоолоор батлагдсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд мод тарих, арчлах, ургуулах ажлыг зохион байгуулах, хувийн хэвшил, иргэдтэй хамтран ажиллах;

3.2.1.5. Хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох, аймгийн төв, суурин газрын агаар, орчны бохирдлыг бууруулах, хөрсний доройтлоос хамгаалах талаар хариуцсан чиг үүргээ хэрэгжүүлж ажиллах;

3.2.1.6. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 64 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-г ач холбогдлыг олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах, тус үзэл баримтлалд туссан зорилтуудыг чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэн ажиллах,

3.2.1.7. “Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2022 оны 419 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж ажиллах, Улаанбаатар хотоос хөдөө орон нутагт шилжин суурьших иргэдийн ажиллаж, амьдрах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх, орон нутагт үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгжийг дэмжиж ажиллах.

3.3.2.2. Төрийн албаны чиглэлээр

3.2.2.1. Төрийн албаны тухай хууль тогтоомжийг чанд мөрдөж, төрийн албаны ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулах;

3.2.2.2. Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсгийн дагуу сул орон тооны захиалгыг тухай бүр хүргүүлэх, төрийн албан тушаалд иргэнийг томилохдоо хууль тогтоомжийг зөрчихгүй ажиллах, хууль зөрчсөн тохиолдолд Төрийн албаны тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээх;

3.2.2.3. Төрийн албан хаагчийн мэргэжлийн ур чадвар, цогц чадамжийг дээшлүүлж, мэргэшүүлэх сургалтад үе шаттай хамрагдах боломжийг бүрдүүлэх, дэмжлэг үзүүлэх, эрхэлсэн ажил, албандаа чин сэтгэлээсээ хандах уур амьсгалыг бүрдүүлэн, нийгмийн баталгааг хангах асуудлыг үе шаттай шийдвэрлэх;

3.2.2.4. Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолын 4.6 /Аймаг, нийслэл, дүүрэг дэх босоо удирдлагатай төрийн байгууллагын жилийн эцсийн тайлангийн гүйцэтгэлийг үнэлэхдээ тухайн нутаг дэвсгэрийн нэгжийн төсвийн шууд захирагч үнэлгээний саналаа 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор харьяалагдах дээд шатны байгууллагын төсвийн шууд захирагчид хүргүүлнэ. Дээд шатны байгууллагын төсвийн шууд захирагч нь орон нутгаас ирсэн үнэлгээний саналыг харгалзан үнэлж, жилийн эцсийн тайлангийн үнэлгээг тухайн нутаг дэвсгэрийн нэгжийн төсвийн шууд захирагчид 1 дүгээр сарын 15-ны өдрийн дотор хүргүүлнэ/-т заасан заалтыг хэрэгжүүлж ажиллах;

3.2.2.5. Монгол улсын Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолын 2.7 /Аймаг, нийслэл, сум, дүүрэгт босоо удирдлагатай байгууллагын албан хаагчийн төлөвлөгөөг тухайн шатны Засаг даргын Тамгын газрын даргын саналыг үндэслэн өөрийн харьяалах төсвийн шууд захирагч хянан тухайн жилийн 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор цахим системд баталгаажуулна/, 5.2 /Аймаг, нийслэл, сум, дүүргийн босоо удирдлагатай байгууллагын албан хаагчийн төлөвлөгөөний гүйцэтгэлийг харьяалах дээд шатны байгууллагын удирдлага үнэлэхдээ тухайн

шатны Засаг даргын Тамгын газрын даргын саналыг тусгана/-т заасан заалтыг хэрэгжүүлж ажиллах;

3.2.2.6.Аймгийн Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнд тогтмол оролцож, аймгийн Засаг дарга, Засаг даргын тамгын газраас өгсөн үүргийг цаг алдалгүй шуурхай хэрэгжүүлж, биелэлтийг тухай бүр тайлагнаж ажиллах;

3.2.2.7.Аймгийн ЗДТГ-т ирүүлбэл зохих хугацаатай албан бичгийн хариу, сарын мэдээ, хагас бүтэн жилийн тайлангуудыг тогтоосон хугацаанд тогтмол ирүүлж хэвших;

3.2.2.8. Төрийн албан хаагчийн Монгол бичгээр баримт бичиг боловсруулах ур чадвар, түвшинг дээшлүүлэх, архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, журам, стандартыг мөрдөж ажиллах;

3.2.2.9. Аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр албан даалгавар /Төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөн явуулах ажлыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай/-ын хэрэгжилтийг хангаж ажиллах;

3.2.2.10.Албан хаагчдын ажлыг дүгнэхдээ Засгийн газрын Хэрэг Эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тогтоолын дагуу бодиттой үнэлж, сахилга хариуцлагыг дээшлүүлж ажиллах;

3.2.3. Санхүү төсвийн чиглэлээр

3.2.3.1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, өр авлага үүсгэхгүй байх, төсвийн зарцуулалтад хяналт тавьж төсвийн хэмнэлтийн горимоор ажиллах

3.2.3.2. Ил тод, үр ашигтай төсвийн бодлогыг хэрэгжүүлж, төсвийн болон орон нутгийн сангуудын үйл ажиллагааг ил тод болгон, төсвийн үр ашгийг сайжруулж ажиллах;

3.2.3.3. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу ажлын үе шатны хяналтыг сайжруулан төлөвлөсөн хугацаанд дуусгах арга хэмжээ авах;

3.2.3.4. Орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэх.

3.2.4. Цахим засаглалыг нэвтрүүлэх, цахим шилжилтийг хэрэгжүүлэх хүрээнд

3.2.4.1.Төрийн цаасан суурьтай үйл ажиллагааг багасган цахим хэлбэрт шилжүүлж, төрийн үйлчилгээний шат дамжлагыг багасгах, чанар хүртээмжийг сайжруулах;

3.2.4.2. Төрийн үйлчилгээнд цахим систем нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх, системийн сургалтын үйл ажиллагаанд холбогдох албан хаагчийг идэвхтэй оролцуулах, төрийн үйлчилгээний чанар, шийдвэрлэлтэд хяналт тавьж тайлагнах;

3.2.4.3. Төрийн байгууллагын мэдээллийн аюулгүй байдлыг дээшлүүлэх, албан хэрэг хөтлөлт, дотоод удирдлагын программ хангамжийг нэвтрүүлэх, хөгжүүлэх;

3.2.4.4. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн санал хүсэлт, өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлэн хариу өгөх, шуурхай, хүнд суртал, чирэгдэлгүй зохион байгуулж, шийдвэрлэлтэд ахиц дэвшил гаргах;

3.2.4.5. Байгууллагын албан ёсны цахим хуудсыг тогтмол ажиллуулж мэдээ мэдээллийг тухай бүр шинэчилж, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн шалгуур үзүүлэлтүүдийн дагуу өөрийн байгууллагад хамаарах мэдээллийг цахим хуудсанд оруулж байх;

3.2.4.6. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангаж ажиллах, орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран иргэд олон нийтэд үйл ажиллагаагаа нээлттэй сурталчлан таниулах.

3.2.4.7. “Цахим гарын үсгийн тухай хууль”-ийн 6.2, 6.3, 6.4 “Нийтийн

мэдээллийн ил тод байдлын тухай хууль”ийн 4.1.9 дэх заалтуудыг хэрэгжүүлж тоон гарын үсгийг төрийн байгууллагын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх

3.2.5. Бусад

3.2.5.1. Энэхүү гэрээний хавсралт болох “Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд тусгагдсан гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээг үр дүнгийн үзүүлэлт, шалгуур үзүүлэлтийн зорилтот түвшинд хүргэж бүрэн хэрэгжүүлж ажиллах;

3.2.5.2. Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн хөгжлийн 2025 оны жилийн төлөвлөгөөний өөрийн байгууллагад хамааралтай арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх, хөгжлийн бодлогын бусад баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, гүйцэтгэл, үр дүнг тайлагнах;

3.2.5.3. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын Архангай аймгийн Засаг даргатай 2025 онд байгуулсан хамтран ажиллах гэрээний заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллах;

3.2.5.4. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах;

3.2.5.5. Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, Засгийн газар, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг сурталчлах ажлыг аймгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим сүлжээг ашиглан шуурхай зохион байгуулах, иргэд, орон нутгийн захиргааны байгууллагын мэдээллийн эргэх урсгалыг тогтмолжуулах;

3.2.5.6. Байгууллагын барилга байгууламж, түүний орчны зам талбайг хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настан зэрэг хүмүүст хүртээмжтэй болгох арга хэмжээг хэрэгжүүлэх;

3.2.5.7. Албан томилолт болон хувийн ажлаар Улаанбаатар хот бусад аймаг, орон нутаг, гадаадад явахдаа аймгийн Засаг даргад мэдэгдэж зөвшөөрөл авах;

3.2.5.8. Байгалийн гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг үнэлэх, агаар, орчны бохирдлын хяналт-шинжилгээний ажилд шаардлагатай үед санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

3.2.5.9. “Соёл урлагийг дэмжих” хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллах;

3.2.5.10. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдүүлэх, дэд бүтэц MNS 6055:2009 стандартыг ханган ажиллах;

3.2.5.11. Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3 /Ажил олгогч нь ажил, амралтын цагийг зохицуулах, хөдөлмөр эрхлэлтийн уян хатан нөхцөл хэрэглэх зэргээр ажилтны ажил, амьдралын тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлэх, хамтын гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд тусгах замаар ажилтны хүүхдэд ээлтэй, хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлнэ/ -т заасан заалтыг хэрэгжүүлж ажиллах;

3.2.5.12. Батлан хамгаалах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 /Ажилтныхаа иргэний цэргийн алба хаах үүргийг биелүүлэх нөхцөлийг бүрдүүлж, цэргийн үүрэгтний дайчилгаатай сургууль, цугларалтад оролцуулах/-т заасан заалтыг хэрэгжүүлж ажиллах;

3.2.5.13. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд төрийн албан хаагчдыг бүрэн хамруулах;

3.2.5.14. Ахмадын настны тухай хуулийн 4-р зүйлийн 4.1.2, Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолоор батлагдсан “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-ын хэрэгжилтийг хангаж, тэтгэвэрт бэлтгэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

3.2.6.15. Төрийн албаны удирдах ажилтны манлайллын зорилтын хүрээнд дор дурдсан арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Манлайллын зорилт	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт		
		Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	Хугацаа
Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, ашиг сонирхлын зөрчил, авлигаас сэргийлэх талаар				
1. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм, Төрийн албан хаагчийн “Эрхэмлэх 9 зүйл” болон бусад дүрмийг сахин биелүүлнэ.	1.1. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм, бусад дүрмийг хэрэгжүүлэх, төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлж ажиллах	Төлөвлөгөө баталж ажилласан эсэх Тийм-1 Үгүй-0	-1 -Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилгүй ажилласан байна	Жилдээ
	1.2. Ёс зүйн зөвлөл байгуулж, ажлын төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг ханган ажиллах, сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах	Хэрэгжилтийн хувь Сургалтын тоо	100% 2-оос доошгүй	Жилдээ
Байгууллагын ил тод байдлыг хангах талаар				
2. Байгууллагын үйл ажиллагааны болон хүний нөөцийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг хэрэгжүүлнэ.	2.1. Байгууллагын эрхэм, зорилго, зорилт, хөтөлбөр, төлөвлөгөө, үйл ажиллагааны талаар цахим хуудас болон мэдээллийн самбартаа ил тод мэдээлэх	Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал хангагдсан байх	Цахим хуудсанд байршуулах мэдээллийг бүрэн байршуулж, шинэчилсэн байна	Жилдээ
	2.2. Гаргасан шийдвэрээ мэдээллийн самбар, цахим хуудсанд байрлуулах	Гаргасан шийдвэр ил тод болсон эсэх Тийм-1 Үгүй -0	1	Жилдээ
Төсвийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтын ил тод байдлыг хангах талаар				
3. Төсвийн тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нийцүүлэн төсвийг захиран зарцуулж, зөрчил дутагдалгүй ажиллана.	3.1.Батлагдсан төсвийн дагуу зарцуулалтыг сайжруулж, өр авлагагүй ажиллах, шилэн дансны хөтлөлтийг 100 хувь хангаж ажиллах	-Төсвийн зарцуулалт -Өр авлага	-Төсвийн сар, улирлын хуваарийн дагуу зарцуулсан байна. -Өр авлага гаргахгүй ажилласан байна.	Жилдээ
	3.2. Төсвийн гүйцэтгэл, өр авлагын сар бүрийн мэдээг үнэн зөв гаргаж Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлэх	Хүргүүлсэн мэдээний тоо	12	Дараа сарын 05-ны өдрийн дотор
4. Нягтлан бодох бүртгэлийн хариуцлагыг дээшлүүлж, санхүүгийн ажилтнуудын үйл	4.1.Төсвийн тухай хуульд заасны дагуу төсвийн шууд захирагчийн урьд оны тайланг аудитын байгууллагаар баталгаажуулах	Дүгнэлт гаргуулсан байх	Зөрчилгүй дүгнэлттэй ажилласан байна.	Эхний хагас жилд

ажиллагаанд тавих хяналтыг сайжруулна.	4.2. Санхүүгийн ажилтнуудыг чадавхижуулах, мэргэшүүлэх арга хэмжээ авах, санхүүгийн ажилтнуудын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах	Санхүүгийн ажилтныг мэргэшүүлэх, чадавхжуулах арга хэмжээнд хамруулсан байх	Сургалтанд хамруулсан байна	Жилдээ
Байгууллагын эд хөрөнгийг зохистой ашиглах талаар				
5. Байгууллагын эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулна	5.1. Өмч эзэмшүүлэх гэрээ байгуулж жил бүр дүгнэж ажиллах, байгууллагын тохижилт, өнгө үзэмжийг сайжруулах арга хэмжээ зохион байгуулах	Гэрээ байгуулж ажилласан байх	Өмч хөрөнгийн ашиглалт хадгалалт хамгаалалт сайжирсан байна.	3, 4-р улиралд
	5.2. Байгууллагын эд хөрөнгийн хувийн хэргийн хөтлөлт, техникийн паспорт, хөрөнгийн картыг шинэчилж баяжуулах	Хөрөнгийн бүртгэл, хөтлөлтийн түвшин	Хөрөнгийн бүртгэл, хөтлөлт сайжирсан байна.	Хагас, бүтэн жилээр
	5.3. Өмч хөрөнгийн тооллогыг хуулийн дагуу тогтсон хугацаанд зохион байгуулж өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах	Зохион байгуулсан өмч хөрөнгийн тооллогын тоо	2	Хагас, бүтэн жилд
Байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх талаар				
6. Хүний нөөцийн төлөвлөлт, албан хаагчдын ажиллах нөхцөл баталгааг хангах, сургаж мэргэшүүлэх, чадавхжуулах арга хэмжээ зохион байгуулах	6.1. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх	Хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлсэн эсэх Тийм-1 Үгүй -0	1	Жилдээ

3.2.6.13. Мэдлэг чадвараа дээшлүүлэх талаар дор дурдсан зорилтыг хэрэгжүүлнэ.

№	Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт	Зорилтыг хэрэгжүүлэх арга зам	Хуанлийн хугацаа, хүн/өдөр
1	Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт 1. Сургалт семинарт хамрагдах, холбогдох хууль тогтоомжийг судлах	1.1. Төрийн албаны тухай хууль, түүнд нийцүүлэн гарсан дүрэм журам, холбогдох хууль тогтоомжийг судлах, хэрэгжүүлж ажиллах 1.2. Дээд шатны байгууллага, аймгийн ЗДТГ-аас зохион байгуулж буй хурал зөвлөгөөн, сургалт семинарт оролцох	20 х/ө
2	Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт 2. Харилцааны ур чадвараа дээшлүүлэх	2.1. Төрийн байгууллагын залгамж чанарыг хадгалж багаар ажиллах, мэргэжилтэн, албан хаагчдыг нэг нэгийгээ орлон ажиллах дадал туршлагад суралцуулах 2.2. Бусдад урам өгч тэдний үйл ажиллагаа мэргэшлийн түвшинг шударга үнэлэх, ажилтан бүрийн тэгш оролцоог хангах 2.3. Төрийн захиргааны болон үйлчилгээний стандартыг мөрдүүлж, төрийн үйлчилгээний шуурхай хүртээмжтэй байдлыг хангах 2.4. Монгол бичгийн ур чадвараа дээшлүүлэх, албан хэргийг хос бичгээр хөтлөн явуулах	20 х/ө

ДӨРӨВ. ГЭРЭЭНД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

4.1. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэж, албажуулан гэрээнд хавсаргана. Энэхүү гэрээний хугацаа сунгагдахгүй.

ТАВ. ГЭРЭЭ БАЙГУУЛАХ, ДҮГНЭХ ХУГАЦАА

5.1. Гэрээг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаагаар байгуулав.

5.2. Төсвийн шууд захирагч гэрээний биелэлтийг 2025 оны 06, 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор багтаан тайлагнаж, Төсвийн ерөнхийлөн захирагч 2025 оны 06, 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор багтаан биелэлтийг дүгнэнэ.

ЗУРГАА. ГЭРЭЭНИЙ УРАМШУУЛАЛ БА ХАРИУЦЛАГА


6.1. Төсвийн шууд захирагч гэрээгээр хүлээсэн үүргээ хангалттай сайн биелүүлсэн тохиолдолд түүнийг урамшуулах асуудлыг төсвийн ерөнхийлөн захирагч Төрийн албаны тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, аймгийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/143 дугаар захирамж/аймгийн Засаг даргын 2022 оны А/394 дүгээр захирамжаар нэмэлт өөрчлөлт оруулсан/-аар батлагдсан “Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын дагуу шийдвэрлэнэ.

6.2. Төсвийн шууд захирагч гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр тухайн оны үр дүнгийн гэрээний биелэлтээ Төсвийн ерөнхийлөн захирагчид ирүүлээгүй эсхүл хугацаа хоцорч ирүүлсэн бол Төрийн албаны тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид заасны дагуу түүнд хариуцлага хүлээлгэнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Төсвийн ерөнхийлөн захирагч

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА


(огноо)

Б.ЦЭРЭННАДМИД

Төсвийн шууд захирагч

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА


(огноо)

Ч. ОТГОНЖАРГАЛ